



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-  
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ЦОЛМОНГИЙН ГАНБАТ ТАНАА

2024.08.08 № 01/814  
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Цолмонгийн Ганбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Цолモンгийн Ганбатын Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Цолмонгийн Ганбатын сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Цолмонгийн Ганбатад

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИГЧ ЦОЛМОНГИЙН ГАНБАТЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.22

Хөхөө

НЭГ. Ерөнхий агуулга

Сум орон нутгийнхаа хөгжил дэвшилийн төлөө санал санаачилга, идэвх оролцоотой байж, иргэд, сонгогчдынхоо итгэлийг зүтгэлээр хариулан, төригэнийг холбон ажиллана.

ХОЁР. Хөтөлбөрийн үндсэн заалт

- Чандмань-Өндөр, Хатгал, Мөрөн чиглэлийн зам засварын ажил, Хонгорын хошуу, Хэц давааны зам засварын ажлыг судалгаа шинжилгээнд тулгуурлан хийхэд анхаарна.
- Улаан-Асга багийн төвийн 35/0,4 кв-ын дэд станцыг байнгын ашиглалтад оруулж 0,4 кв цахилгаан дамжуулах агаарын шугам барьж хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж дэмжиж ажиллана.
- Сумын төвийн хороолол, газруудад шаардлагатай байгаа дэд станцуудыг шинээр барихад анхаарч ажиллана. (Тухайлбал Сагадай хороолол)
- Улаан-Асга багийн гэр цэцэрлэгийн байрыг жил бүр тогтмол ажиллуулахад анхаарал хандуулж ажиллана.
- Малчдын өвөлжөө, хаваржааны газрыг кадастрт оруулах, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулахад анхаарна.
- Булнайд үүрэн телефоны сүлжээ оруулах тал дээр холбогдох байгууллагад санал хүргүүлж ажиллана.
- Багийн иргэдийн эрүүл мэнд, спортын чиглэлээр жил бүр урлаг, спортын наадам зохион байгуулна.
- Багийн төвийн хил хязгаарт тэмдэг тэмдэглэгээг хийж отрын бүс нутаг шинэчлэн тогтоох ажлыг санаачлан шийдвэр гаргуулна.
- Улаан-Асга багийн төвийн уст цэг, гүний худгийг түшиглэн хүнсний ногоо тариалах ажлыг дэмжиж ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН: Ц.ГАНБАТ

00000001

